

## Монгол дахь бичил зээлийн хүүгийн судалгаа

Док. Б. Энхцэцэг, МУИС-ийн ЭЗС-ийн Хүн Амын Сургалт,  
Судалгааны Төвийн ахлах багш  
Ө. Гэрэлт-Од, докторант, МУИС, ЭЗС-ийн Санхүүгийн  
тэнхмийн ахлах багш

Монгол улсын санхүүгийн зах зээлийн өрөөсгөл хөгжил санхүүгийн зах зээлийн өрсөлдөөний хүчийг ихээхэн бууруулдаг. Санхүүгийн зах зээлд нөөцийн дахин хуваарилалт банкуудаас гадна үнэт цаасны зах зээл, мэргэжлийн санхүүгийн байгууллагуудаар дамжин хэрэгжиж байдаг хэдий ч эдгээрээс үнэт цаасаарх хөрөнгө оруулалт маш бага, санхүүгийн хөрөнгө оруулалтын компани үүсч бий болж амжаагүй байгаа учир банкууд уг зах зээлд ганцаар ноёрхож санхүүгийн бодлого, түүний дотор үнийн бодлогыг тогтоох үндсэн нөхцөл болж байна. Нөгөө талаар санхүүгийн зах зээл дээрээс хөрөнгө босгогч оролцогчдын санхүүгийн боловсрол бага, хөрөнгө оруулалтын хэрэгслэлүүдийг сонголттойгоор ашиглах чадамж муу байгаа нь санхүүгийн зах зээлийн субъекүүдийн хөгжилд саад болж байна.

Бизнес эрхлэгчид өөрт шаардлагатай байгаа хөрөнгийн эрэлтийг сонголттойгоор шийдвэрлэх боломжийг олгодгоороо зах зээлийн эдийн засаг дахь санхүүгийн тогтолцооны төвлөрсөн эдийн засгийн тогтолцооноос ялгагдах давуу тал юм. Гэтэл манай улсын санхүүгийн зах зээлийн өнөөгийн төлөв байдал энэ тодорхойлолтоос ихээхэн ялгагдаж байна. Учир нь зээлийн байгууллагуудаас арилжааны банкууд голлох үүрэгтэйгээр ажиллаж байгаа нь зээлдэгчдэд сонголт хийх боломж хязгаарлагдмал байх нөхцлийг бүрдүүлж байна. Банк бус санхүүгийн байгууллагууд ажиллаж байгаа ч тэдний тоо цөөн, хөрөнгийн хэмжээ бага байгаа нь банкны зах зээлд өрсөлдөгч байх нөхцлийг бууруулж байна.

Түлхүүр үгс: Бичил зээл, зээлийн хүү, зээлийн бодлогын нөлөөлөл, тогтвортой эх үүсвэр

Монгол улсын эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад жижиг бизнес, өрхийн аж ахуйг дэмжин бэхжүүлэх асуудал чухлаар тавигдаж байгаа бөгөөд түүнийг хөгжүүлэхэд төрийн болон олон улсын байгууллага, хандивлагч орнууд идэвх чармайлт гарган ажиллаж байна. Үндэсний болон гадаадын хөрөнгө оруулагчдын ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт бичил жижиг бизнесийг дэмжихэд зориулагдаж байгаа бөгөөд түүний үр дүнг Монгол улсын эдийн засгийн сүүлийн жилүүдэд бий болж буй тогтвортой өсөлттэй холбон тайлбарлаж болно.

Монгол улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээр аж ахуйн олон төрлийн хэвшил шинээр бий болон хөгжиж байгаагийн нэг хэлбэр нь бичил аж ахуй юм. Түүний хөгжилд хөрөнгө оруулалтын найдвартай хямд эх үүсвэр

зайшгүй шаардагдаж байгаа. Монгол улсын Засгийн газар, хандивлагч олон улсын байгууллагуудын үүсэл санаачлагаар хөдөө орон нутагт болон Улаанбаатар хотод бичил санхүүгийн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх зорилго бүхий санхүүгийн байгууллагууд олноор байгуулагдан ажиллаж байна.

### Бичил зээлийн орчин

Бичил зээлийн өвөрмөц шинж чанараас хамааран зохион байгуулалтын өвөрмөц орчинг шаарддаг. Бичил зээлийн зохион байгуулалтын асуудал дан ганц санхүүгийн байгууллагынх биш бөгөөд түүнд төрийн оролцоо онцгой байр суурийг эзэлдэг. Төр жижиг дунд бизнесийн эрх зүйн орчинг бүрдүүлэх, тэдгээрт шаардагдах хөрөнгө оруулалтын санг бий болгох, санхүүгийн байгууллагуудыг тухайн үйл ажиллагаанд татан оролцуулах зэргээр өргөн хүрээнд ажилладаг.

Монгол улс 2007 онд “Жижиг дунд үйлдвэрлэлийн тухай” хуулийг батлан гаргасан бөгөөд ААН, өрхийн бизнесийг орлого ба ажлын байрны хэмжээ, үйл ажиллагааны чиглэлээр нь дараах ойлголтуудад хамааруулах тухай заажээ (Хүснэгт 1). Энэхүү хуулийн заалтын үндэслэлийг тодорхойлсон суурь судалгаа байгаа гэдэгт найдаж байгаа бөгөөд өнөөдөр үйл ажиллагаа эрхлэж байгаа нийт ААН, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн орлогын багцын судалгаа, ажлын байрны судалгаанд

үндэслэсэн бизээ. Нэгэнт суурь судалгаа хийгдсэн бол эдгээрийн нийт хөрөнгийн хэмжээ ба өр төлбөрийн хэмжээ, төлбөрийн чадвар зэрэг үзүүлэлтийг үнэлэх замаар тэдгээрт шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээ, санхүүжүүлэх эх үүсвэр зэргийг тогтоох зайлшгүй шаардлагатай бөгөөд уг судалгааг бичил, жижиг, дунд гэсэн чиглэлээр хийж бичил зээлийн эрэлтийг судлах шаардлагатай, энэ нь цаашид шаардагдах зээлийн нөөцийг тогтоох суурь болно.

Хүснэгт 1. Монгол улсын “Жижиг Дунд Үйлдвэр”-ийн тухай хуулиас

Да	Жижиг дунд үйлдвэрлэ-лийн ангилал	Хамаараг-дах субъект	Үйл ажиллагааны чиглэл	Ажлын байрны тоо			Борлуулалтын орлогын хэмжээ
				Байнгын	Гэрээ-гээр	Нийт	
1	Дунд үйлдвэр	ААН, иргэн	Үйлдвэрлэл			199	1,5 тэр бум төг хүртэл
			Бөөний худалдаа			149	1,5 тэр бум төг хүртэл
			Жижиглэнгийн худалдаа			199	1 тэр бум төг хүртэл
			Үйлчилгээ			49	1 тэр бум төг хүртэл
2	Жижиг үйлдвэр	ААН, иргэн	Үйлдвэрлэл		19	9	250 сая төг хүртэл

Эх үүсвэр: Монгол Улсын Их Хурал, 2007. МУ-ын Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль, 2007.07.06

Жижиг бизнесийг дэмжих үндсэн хэлбэр нь хөрөнгө оруулалт юм. Жижиг бизнесийн нийгэм, эдийн засгийн үр ашгийг үндэслэн хөрөнгө оруулалтын бодлогыг оновчтой хэрэгжүүлснээр эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах боломжтой. Санхүүгийн байгууллагуудын хөрөнгө оруулалтыг жижиг бизнест оруулахад эрсдэлээс хамаарсан өндөр хүү зээлдэгчийг төлбөрийн дарамтанд оруулах, нөгөө талаас, бизнес эрхлэгчдийн хөрөнгө оруулалтын зорилго зээлдүүлэх сонирхолтой зөрчилддөг хүндрэлүүд гардаг тул “Сан” байгуулах замаар хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэх хэлбэр түгээмэл ашиглагддаг. Санг төрийн (орон нутгийн хөрөнгө) болон олон улсын байгууллагын хөрөнгө, бизнесийн ба санхүүгийн байгууллагын хөрөнгөөр байгуулж болдог ба санг хуваарилах дараах хэлбэрүүдийг өргөн ашигладаг. Үүнд:

1. Зээлийн эрсдэлийг үнэлэн зээлжих дарааллыг тогтоох: Эрсдэл багатай, эдийн засгийн үр ашигтай салбарыг эхлэн зээлжүүлэх хэлбэрээр хэрэгжинэ. Энэ тохиолдолд зээлдэгч зээлийн эрсдэлийг үүрдэг.
2. Зээлийн эрсдэлээс хамаарсан ба үл хамаарсан байдлаар зээлжүүлэх дарааллыг тогтоох: Санг орлого өндөртэй салбарт зээлдүүлэхээс гадна төслийн нийгэм, эдийн засгийн зайлшгүй шаардлагатай салбарт олгох.
3. Эрсдэлийн үнэлгээг үл хамаарсан байдлаар зээлжүүлэх: Энэ хэлбэр нь:

- Санг тэгшитгэн хуваарилах;
- Санг ашиглах хүсэлт гаргасан дарааллыг үндэслэх;
- Нийгэм, эдийн засгийн үр ашгийг үнэлэх гэсэн хувилбаруудтай байх боломжтой.

*Арилжааны банкны бичил зээлийн хүүгийн түвшин түүний цаашдын хандлага, хүүд нөлөөлөх хүчин зүйлс*

Зээлийн хүүд нөлөөлдөг хүчин зүйлс олон бөгөөд эдгээр нь хүүд шууд ба дам нөлөөллийг үзүүлнэ. Зээлийн зах зээл дэх эрэлт нийлүүлэлтийн харьцаан дээр зээлийн хүү тогтоно. Зах зээлд шаардлагатай байгаа хөрөнгө оруулалт, зээлийн эрэлтийг хангах нөөцийн хүрээнд санхүүгийн байгууллагууд ажилладаг. Бичил зээлийн үндсэн зориулалт хэрэглээг урамшуулахад чиглэгддэг бол Монгол улсад хэрэгжиж буй бичил зээлийн төслүүд бага орлоготой иргэд болон жижиг бизнесийг дэмжихэд чиглэгддэг. Бичил жижиг бизнесийн хөрөнгийн эргэц түргэн байдаг учир зээлийн хугацаа богино, ихэнх хэрэглээний зээлийн нэг адил зах зээлийн хүүд ихээхэн мэдрэмжтэй байдаг учир бичил зээлийн зах зээлд хүүгийн нормыг зохицуулалтыг хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл болон ашиглагддаг. Өнөөгийн байдлаар банкуудын бичил бизнесийн зээлийн хэмжээ бага, хугацаа богино байдаг нь зээлдэгчдийн төлбөрийн чадварын хүндрэл, зээлийн эрсдэл өндөр, банкуудын ажиллагааны зардал их байдагтай холбон тайлбарлаж болно. Монгол улсын санхүүгийн зах зээлийн өрөөсгөл хөгжил санхүүгийн зах зээлийн өрсөлдөөний хүчийг ихээхэн бууруулдаг. Санхүүгийн зах зээлд нөөцийн дахин хуваарилалт банкуудаас гадна үнэт цаасны зах зээл, мэргэжлийн санхүүгийн байгууллагуудаар дамжин хэрэгжиж байдаг хэдий ч эдгээрээс үнэт цаасаар хөрөнгө оруулалт маш бага,

санхүүгийн хөрөнгө оруулалтын компани үүсч бий болж амжаагүй байгаа учир банкууд уг зах зээлд ганцаар ноёрхож санхүүгийн бодлого, түүний дотор үнийн бодлогыг тогтоох үндсэн нөхцөл болж байна. Нөгөө талаар санхүүгийн зах зээл дээрээс хөрөнгө босгогч оролцогчдын санхүүгийн боловсрол бага, хөрөнгө оруулалтын хэрэгслэлүүдийг сонголттойгоор ашиглах чадамж муу байгаа нь санхүүгийн зах зээлийн субъекүүдийн хөгжилд саад болж байна.

Бизнес эрхлэгчид өөрт шаардлагатай байгаа хөрөнгийн эрэлтийг сонголттойгоор шийдвэрлэх боломжийг олгодгоороо зах зээлийн эдийн засаг дахь санхүүгийн тогтолцооны төвлөрсөн эдийн засгийн тогтолцооноос ялгагдах давуу тал юм. Гэтэл манай улсын санхүүгийн зах зээлийн өнөөгийн төлөв байдал энэ тодорхойлолтоос ихээхэн ялгагдаж байна. Учир нь зээлийн байгууллагуудаас арилжааны банкууд голлох үүрэгтэйгээр ажиллаж байгаа нь зээлдэгчдэд сонголт хийх боломж хязгаарлагдмал байх нөхцлийг бүрдүүлж байна.

Банк бус санхүүгийн байгууллагууд ажиллаж байгаа ч тэдний тоо цөөн, хөрөнгийн хэмжээ бага байгаа нь банкны зах зээлд өрсөлдөгч байх нөхцлийг бууруулж байна.

*Зээлийн хүүг бууруулах боломж, арга зам*

Санхүүгийн зуучлагчдын эдийн засаг, нийгмийн үүрэг, бизнесийн сонирхол байнга зөрчилдөж байдгаас түүний үйл ажиллагааг төрөөс зохицуулах зайлшгүй шаардлага бий болдог. Төрийн зохицуулалтын нөлөө, тухайлбал, төрийн мөнгөний бодлого сангийн бодлого банкны ажиллагаанд шууд нөлөөллийг үзүүлж байдаг. Монгол улс 2006 онд банкны зээлийн хүүг бууруулах замаар банкны санхүүгийн зуучлалыг нэмэгдүүлэн эдийн засгийг хөрөнгө оруулалтаар дэмжих хүрээнд төрийн бодлого хэрэгжүүлэн ажиллаж байна.

Зээлийн хүүг бууруулах нь банкны бизнесийн сонирхолтой зөрчилдөх учир хэрэгжүүлэх арга хэрэгслийн сонголтыг оновчтой хийх зайлшгүй шаардлагатай.

Төрийн зүгээс болон банк өөрийн дотоод нөөцийн хүрээнд зээлийн хүүг бууруулахад ямар арга хэмжээг авч хэрэгжүүлбэл зохистой байх вэ? Төр ба банк гэсэн хоёр хүчин зүйл буюу зохицуулалт ба үйл ажиллагаа гэсэн хоёр хүчин зүйлээс шууд хамааралтай. Нөгөө талаар банк эдийн засгийн тогтолцооны үндсэн субъект гэдэг утгаараа банкны үйл ажиллагаа макро эдийн засгийн нөхцөл байдалтай шууд холбогддог.

Банкны дотоод хүчин зүйл болох үйл ажиллагааны зардлыг (C) банк өөрөө зохицуулдаг бол N (Заавал Байх Нөөц)-ийн хэмжээг төр зохицуулдаг, эх үүсвэрийн зардалд төрийн бодлого, зохицуулалт ба банкны дотоод хүчин зүйлс хамаардаг. Эдийн засагдах инфляцийн хэмжээ өсөх нь эх үүсвэрийн зардлыг нэмэгдүүлэхээс гадна банкны зах зээлийн өрсөлдөөн нь эх үүсвэрийн зардал өсөхөд нөлөөлдөг. Банкны зээлийн хүүг хэд хэдэн янзаар тодорхойлж болно. Үүнд:

1. Банкны хувьд зээлийн хүү эх үүсвэрийн зардал, үйл ажиллагааны зардал, заавал байлгах нөөцийн зардал, инфляци, тухайн жилийн зорилтот ашгийн нормоос хамаарна

$$I_L = I_D + C + N + A + R + Inf$$

$I_D$  - Эх үүсвэрийн зардал буюу депозит, дайчлагдсан хөрөнгийн үнэ цэнэ (хүү)

C - Үйл ажиллагааны зардал

N - ЗБН-ын хэмжээ

A - Зорилтот ашгийн хэмжээ

R - Эрсдэлийн норм

Inf - инфляци (тухайн жилийн хүлээгдэж буй инфляцийн хэмжээ)

Зээлийн хүү нь зээлдэгч ба зээлдүүлэгчийн хооронд орлого болон эрсдлийг хуваарилах хэрэгсэл юм. Зээлдэгч тухайн хөрөнгөөс олсон орлогоос зээлдүүлэгчид орлого хуваарилдаг хэрэгсэл нь зээлийн хүү юм. Нөгөө талаар, зээлийн хүү нь зээлдүүлэгчид тухайн хөрөнгөтэй холбогдон үүсэх эрсдэлийг зээлдэгчдэд хуваарилах хэрэгсэл болдог.

2. Зээлдэгчийн хувьд зээлийн ажиллагаатай холбогдон гарсан бүхий л зардлыг зээлийн хүү гэж тооцдог. Тухайлбал, зээлийн гэрээг баталгаажуулах, зээлийн гэрээ байгуулах болон санхүүгийн зөвлөгөө авах, хөрөнгийн үнэлгээ, даатгал гэх мэт үйлчилгээний зардлууд зээлтэй холбогдон гарах бөгөөд түүнийг зээлдэгч зээлийн төлбөр буюу зээлтэй холбогдон гарах зардал, хүүтэй адилтгах зардал гэж үздэг.

Банкны зээлийн хүүг тодорхойлогч  $I_D, C, N, A, R, inf$  хувьсагчдад банкны дотоод ба гадаад хүчин зүйлс нөлөөлдөг. Эдийн засагдах инфляцийн хувь хэмжээ эх үүсвэрийн өртөг ба эрсдэлийн хувь хэмжээ, зорилтот ашгийн, үйл ажиллагааны зардалд нөлөөлдөг. Банкны системийн хэмжээнд эх үүсвэрийн өртөг буюу эх үүсвэрийн хүү тасралтгүй буурч байгаа байхад үйл ажиллагааны зардал өссөн дүнтэй байна.

**Банкны үйл ажиллагааны зардал:** Банкны үйл ажиллагааны зардал гэдэгт хүүгийн бус зардлыг ойлгодог. Банкны үйл ажиллагааны зардал нь активын эрсдэлийн хэмжээ, банкуудын салбарын тоо буюу ажлын байрны тоо, зорилтот зах зээлийн төлөв зэргээс хамаардаг. Жижиг бизнес хэрэглэгчдэд чиглэсэн зах зээлийн бодлого нь банкны үйл ажиллагааны зардал өндөр байх нөхцөл болдог.

Нийт зардалд суурилан (ашиг=0) зээлийн активын суурь өртгийг тооцвол: банкны системийн хэмжээнд 16,1 хувь, Хаан банк 16,6 хувь, Хас Банк 18,1 хувь байна (Хүснэгт 2).

## Хүснэгт 2. Хүүгийн ба хүүгийн бус зардлын харьцаа

Үзүүлэлтүүд	Хүүгийн зардал (хувиар)	Хүүгийн бус зардал (хувиар)	Хүүгийн зардал /Хүүгийн бус зардал
Банкны системийн дундаж	3,45	4,28	0,81
Хаан банк	4,49	4,1	1,09
Хас банк	4,36	5,1	0,85

Банк бизнесийн байгууллага болохынхоо хувьд татвар төлөгч байдаг бөгөөд банк нийтлэг татвар төлөгч байх уу, түүнд бусад татвартөлөгчдөөс ялгаатай бодлого баримтлах уу гэдэг үндсэн 2 зарчим байдаг. Банк ихэнх оронд бизнесийн байгууллагын адил татвар төлөгч байдаг хэдий ч өрсөлдөөний жигд бус байдал эдийн засгийн тогтолцоонд түүний гүйцэтгэх үүргийн хүрээнд бизнесийн байгууллагуудаас ялгаатай бодлого хэрэгжих нь бий, энэ нь төрийн мөнгөний бодлогын хүрээнд цонхны зохицуулалтын бодлого хэрэгжиж байх үед мөрдөгдөх нь элбэг байдаг.

Эдийн засгийн тогтвортой байдлыг санхүүгийн активуудын тогтворжилтоор илэрхийлнэ гэж үздэг. Банкууд тогтвортой эх үүсвэр эзэмшсэнээр активын тогтвортой байдал хангагдах бөгөөд энэхүү нөхцөл банкыг урт хугацаанд хөрөнгө оруулагчийн үүргээр ажиллах нөхцлийг бүрдүүлнэ. Монгол улсын банкны системийн хэмжээнд нийт активт зээлийн эзлэх хувь хэмжээ тасралтгүй өсч байгаа нь мөнгөний нийлүүлэлтэд нөлөөлөн цаашид инфляцид нөлөөлөх магадлал өндөр юм. Манай санхүүгийн зах зээлд зээлийн үндсэн хэрэгслэл нь банкны зээл байгаа

бөгөөд үнэт цаасны зах зээлийн хөгжлийн зогсонги байдалтай холбоотойгоор банкуудын үнэт цаасны зах зээлд гарч ажиллах боломж харьцангуй хязгаарлагдмал нөхцлийг бий болгож байгаа нь манай банкуудын активын бүтцийг өрөөсгөл хэлбэрт оруулах үндсэн шалтгаануудын нэг юм. Эдийн засгийн үзүүлэлтүүд тогтворжих хандлагатай байгаа нь цаашид санхүүгийн активууд тогтворжих хандлагыг илэрхийлж байна. Энэ нь хөрөнгө оруулалтыг урт хугацаанд төлөвлөх боломжийг бизнес эрхлэгчдэд олгодог бөгөөд цаашид хөрөнгө оруулалтын зориулалтаарх зээлийн эрэлт өсөх шалтгаан болно.

**Зорилтот ашгийн хэмжээ:** Банкны хүүгийн орлого банкны ашигт ажиллагаа, банкны өөрийн хөрөнгийн өгөөж ба активын өгөөжийг тодорхойлдог үндсэн хүчин зүйл билээ. Ашгийн нормыг зорилгоо болгох нь банкны хүүгийн түвшин, эрсдэлийн хэмжээг өсгөдөг. Банкны эдийн засагт гүйцэтгэх онцгой үүрэг банкны үйл ажиллагааг төрийн зүгээс дэмжих шаардлагыг бий болгодог. Төрөөс банкны үйл ажиллагааг татварын бодлогоор дэмждэг.



Банкны ашгийн төлөвлөлтийг татвар төлсний дараах байдлаар хийх нь оновчтой. Татварын хувь хэмжээ өсөх нь зорилтот ашгийн түвшинг өсгөдөг. Судалгааны хамрагдсан хугацаанд Хаан банкны активын өгөөж 4,62 хувь, Хас банк 3,53 хувь байна. Активын өгөөжийг тодорхойлоход улирлын хэлбэлзэл их байгаа бөгөөд банкууд жилийн эхний улирлуудад алдагдалтай, жилийн эцсээр ашигтай ажилладаг, Тээвэр хөгжил, Капитрон, ҮХО-ын банкууд алдагдалтай ажилласан нь системийн хэмжээнд активын өгөөж бага 0,51% байхад нөлөөлсөн үндсэн шалтгаанууд болно.

**Эрсдэлийн түвшин:** Зээлийн эрсдэл банкны эрсдэлийн үндсэн шалтгаануудын нэг юм. Системийн хэмжээнд зээлийн эрсдэл буураагүй тогтвортой байна (Хүснэгт 3).

**Хүснэгт 3. Актив болон зээлийн эрсдэлийн хэмжээ**

Банкууд	Активын эрсдэлийн хэмжээ	Зээлийн эрсдэлийн хэмжээ
Банкны дундаж үзүүлэлт	0,03610	0,05781
Хаан банк	0,0166	0,0250
Хас банк	0,0048	0,0073

Эрсдэлийн үнэлгээг 100 хувь зээлийн хүүд шингээж болохгүй бөгөөд муу зээлийг байгуулсан эрсдэлийн сангаар хаадаг тул бүртгэгдсэн муу зээлийн хэмжээгээр бус банк өөрийн сангаар хаасан муу зээлийн хэмжээгээр эрсдэлийн хувь хэмжээг тооцох хэрэгтэй.

Манай улсын тухайд банкны хөрөнгө оруулалтын үндсэн хэлбэр нь зээл бөгөөд үнэт цаасны зах зээлийн хөгжлийн зогсонги байдалтай холбоотойгоор банкуудын үнэт цаасны зах зээлд гарч ажиллах боломж харьцангуй хязгаарлагдмал нөхцлийг бий болгож байгаа нь манай банкуудын активын бүтцийг өрөөсгөл хэлбэрт оруулах үндсэн шалтгаануудын нэг болж байна.

**Төрийн сангийн бодлогын нөлөөлөл.** Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх тухай үзэл баримтлалыг хэрэгжүүлж эхлээд байгаа өнөө үед тэдгээрийн хөгжлийн жигд байдлыг хангахын тулд төвийн бүсээс бусад бүсэд хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага байгаа бөгөөд түүнийг бүс нутагт чиглэсэн үйлчилгээ үзүүлж буй банкуудыг төвийн бүсэд үйл ажиллагаа явуулж буй банкуудаас ялгаатай татварын бодлого хэрэгжүүлэх замаар дэмжих нь бүс нутаг дах хөрөнгө оруулалтыг дэмжих, хөдөө орон нутаг дах банкны үйлчилгээний хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх боломжтой.

**Төрийн мөнгө зээлийн бодлогын нөлөөлөл.** Мөнгөний захын активуудын арилжааны хэмжээ ба үнэ цэнэд мөнгө зээлийн бодлого шууд ба шууд бус нөлөөллийг үзүүлдэг. Үүний нэг адил бичил зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хүүд нөлөөлөх дам ба шууд хүчин зүйлсийг зохицуулах замаар зээлийн хүүг бууруулахад мөнгө зээлийн бодлогын зохицуулалтын арга хэрэгслүүд үйлчилнэ. Төрийн мөнгө зээлийн бодлого инфляци, валютын ханш, банкны нийт нөөц, зээлийн бодлогын нөлөөллийн (ЗБН) нормыг зохицуулах замаар хэрэгждэг бөгөөд эдгээр хүчин зүйлсийг бичил зээлийн хүүг зохицуулах зохицуулалтын арга хэрэгсэл болон ашиглагдах боломжтой. Төрийн мөнгө зээлийн бодлогын хүрээнд банкны ЗБН-ийг 14 хувиас 5 хувь болгон бууруулснаар банкууд зээлийн хүүг бууруулах боломжийг бий болгожээ.

Банкын системийн хэмжээнд төгрөгийн зээлийн хүү ба эх үүсвэрийн зардлын зөрүү  $Spread^T = 30\% - 8\% = 22\%$ , ам.долларын зээлийн хүү ба эх үүсвэрийн зардлын зөрүү  $Spread^S = 24\% - 5\% = 19\%$  буюу зээлийн хүү эх үүсвэрийн зардлаас 3-4 дахин илүү байгаа нь банкууд зээлийн эрсдэлийн норм, хүүгийн бус зардал, төлөвлөгөөт ашгийн хэмжээ хэт өндөр байгааг илэрхийлнэ.

**ЗБН-ийн хэмжээ зээлийн хүүд нөлөөлөх нь:** Төрийн мөнгөний бодлогын хүрээнд 2007 оны 3 сараас эхлэн банкуудын ЗБН-ын хэмжээг өмнөх нөөцийн нормоос даруй 3 дахин бууруулан 5 хувь болгон шинэчилсэн нь зээлийн хүүгийн түвшин буурах таатай нөхцөл болжээ. Нөгөө талаар банкуудын илүүдэл нөөцийн хэмжээ их байгаа нь

зээлийн хүүд сөрөг нөлөө үзүүлдэг. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн эх үүсвэр нэг бүрээс 5% нөөц байршуулахыг Төв банк арилжааны банкуудад санал болгодог, түүнээс илүү хэмжээний нөөцийг байршуулах нь активын өртгийг өсгөх үндсэн шалтгаан болно (Хүснэгт 4).

**Хүснэгт 4. ЗБН-ын нормын өөрчлөлтийн хүүд үзүүлэх нөлөөлөл**

Үзүүлэлтүүд	ЗБН 14% үед		ЗБН 5% үед	
	1	1	1	1
Эх үүсвэр (төг)				
Эх үүсвэрийн үнэ буюу хүү (хувь, жилээр) <sup>1</sup>	5%	8,00%	5%	8,00%
Заавал байлгах нөөцийн норм	0,14	0,14	0,05	0,05
Дахин хуваарилагдах эх үүсвэр	0,86	0,86	0,95	0,95
Ашиг=0 үеийн орлого ба хөрөнгийн хэмжээ	1,05	1,08	1,05	1,08
Илүүдэл нөөцөөр бий болгох орлогын хэмжээ (төг)	0,0581	0,093	0,0526	0,0842
Зээлийн хүүгийн хэмжээ (хувь, жилээр)	5,814%	9,302%	5,263%	8,421%
Эх үүсвэрийн өртөгийн өсөлт	16,28%	16,28%	5,26%	5,26%
Төгрөгийн зээлийн хүүд гарах өөрчлөлт	9%			
Долларын зээлийн хүүд гарах өөрчлөлт	9%			
Төгрөгийн дэд зээлийн хүү	Гэрээгээр		Шинэчлэгдэх	
	I=22%		I - I*(9%) + (зорилтот ашгийн хэмжээ, эрсдэлийн норм, хүүгийн бус зардал)	
Долларын дэд зээлийн хүү	Гэрээгээр		Шинэчлэгдэх	
	I=22%		I - I*(9%) + (зорилтот ашгийн хэмжээ, эрсдэлийн норм, хүүгийн бус зардал)	


Эх үүсвэрийн үнэ бага байх тусам ЗБН-ын нормын зээлийн хүүд үзүүлэх дарамт өсдөг бөгөөд эх үүсвэрийн өртөг 5%-8%, ЗБН-14 хувь, зээлийн үр ашиг тэгтэй тэнцүү үед ЗБН-ын нормын нөлөөллөөр эх үүсвэрийн өртөг 16,28 хувь өсч төгрөгийн болон долларын зээлийн хүү 8%-9,3%, төгрөгийн зээлийн хүү 5%-5,81% болж байгаа бөгөөд хүүд үзүүлэх дарамтыг 16,28 хувь гэж тооцож болно. ЗБН-ын норм 14 хувиас 5 хувь болон буурснаар хүүгийн хувь хэмжээ төгрөгийн ба долларын зээлд ижил түвшинд буюу 9 хувиар буурч хүүгийн төгрөгийн зээлийн хүү 5,81%-5,26%, долларын зээлийн хүү 9,3%-8,4% болж буурсан эерэг нөлөөллийг зээлдэгчид мэдрэх ёстой. Өөрөөр хэлбэл, 2007 оны 3-р сараас хойш зээл авсан нийт зээлдэгчдэд хүүг бууруулан шинэчлэн тогтоох боломжтой болж байна (Хүснэгт 5).

Судалгаанд хамрагдсан хугацаанд банкуудын активын өгөөж 0,00521 буюу 0,51 хувь өөрийн хөрөнгийн өгөөж 0,0424 буюу 4,24 хувь байгаа бөгөөд системийн хэмжээний зардал, эрсдэлийн түвшин, ашиг, ЗБН-ын гэсэн үндсэн үзүүлэлтүүдийг ашиглан системийн дундаж хүүгийн түвшин, Хаан ба Хас банкны хүүгийн түвшинг дараах байдлаар тодорхойллоо. Үүнд: Хас ба Хаан банкууд нь системийн хэмжээнд активын өгөөж хамгийн өндөр буюу Хас банк 0,0353 буюу 3,53 хувь, Хаан банк 0,0462 буюу 4,62 хувь байна. Хүүгийн бус зардал Хаан банкинд 4,07 хувь, Хас банканд 4,36 хувь байгаа бөгөөд төслийн зээлийн суурь хүүг банкуудын зардалд суурилан тооцооход Хаан банк суурь хүүгийн доод түвшин 12,7 хувь дээд хүү 15,85 хувь, Хас банк доод хүү 12,78 хувь, дээд хүү 16,18 хувь байна.


Хүснэгт 5: Банкуудын бичил зээлийн хүү (Зардалд суурилсан)

Банкууд	Эх үүсвэрийн зардал	ЗБН тооцсон байдлаар	Нэгж активт ногдох хүүгийн бус зардал	Нэгж зээлд ногдох хүүгийн бус зардал	Зээлийн доод хүү <sup>2</sup> (Зардалд суурилсан)	Зээлийн дээд хүү <sup>3</sup> (Зардалд суурилсан)
Нэгж активт ногдох хүүгийн ба хүүгийн бус зардалд суурилан тооцов.						
Банкны системн түвшин	0,08	0,0842	0,0428	0,0743	0,1270	0,1585
Хаан банк	0,08	0,0842	0,0407	0,0609	0,1249	0,1451
Хас банк	0,08	0,0842	0,0436	0,0776	0,1278	0,1618

Зураг 2: Банкуудын хүүгийн ба хүүгийн бус зардлын харьцаа



Зураг 3: Банкуудын хүүгийн ба хүүгийн бус орлогын харьцаа



Ашигт суурилсан үнэ тогтоолтын хувьд нийт зардлыг зөвхөн зээлд ногдоно, ашгийн банкны системийн хэмжээнд шинээр нэг үндсэн хэрэгслэл гэж үзээд тухайн тухайн төгрөгийн активыг татан төвлөрүүлэхэд банкуудын активын өгөөжийг үнэлэн 15,85 хувь, Хаан банк 14,51 хувь, Хас банк зээлийн хүүг тооцлоо (Хүснэгт 6) . 16,18 хувь байгаа үед банкны системийн

- 2 Төслийн зээлийн хүү түүнээс бага байх боломжгүй, активын нэг төгрөг тутам ногдох хүүгийн бус зардлын хэмжээ буурах нь цаашид зээлийн хүү буурах нөхцөл болно.
- 3 Зээлийн хүүгийн дэд хязраарыг банкууд өөрсдөө тогтоох бөгөөд дээд хүүг нийт зардлыг зээлийн хүүд шингээж тооцов. Банкуудын ашгийн ба эрсдэлийн нормоос хамаарч зээлийн хүүгийн өснө.



**Хүснэгт 6. Хаан, Хас банкны бичил зээлийн ашигт суурилсан хүү**

Банкууд	Зардалд суурилсан хүүгийн доод түвшин	Зардалд суурилсан хүү дээд хүү (тооцоолсон)	Банкуудын активын өгөөж	Зээлийн доод хүү	Зээлийн дээд хүү
Банкны системн түвшин	12,70%	15,85%	0,52%	13,22%	16,37%
Хаан банк	12,49%	14,51%	4,62%	17,11%	19,13%
Хас банк	12,78%	16,18%	3,53%	16,31%	19,71%

Эндээс зээлийн суурь хүүг төслийн төгрөгийн зээлийн хүүтэй харьцуулбал:

**Хаан банк:** Бичил зээлийн дээд хүү<sup>1</sup> ба судалгаагаар тооцоолсон доод хүүгийн зөрүү  $36\% - 19,31\% = 16,69\%$

**Хас банк:** Бичил зээлийн дээд хүү<sup>2</sup> ба судалгаагаар тооцоолсон доод хүүгийн зөрүү  $36\% - 19,71\% = 16,29\%$ , доод хүү  $28,8\% - 16,31\% = 12,49\%$  байна.

Ийнхүү бичил зээлийн хүүг бууруулах тухай асуудалд банкууд анхаарлаа хандуулах нь илүү зохистой бөгөөд банкууд зээлийн хүүг тооцоходоо ашгийн ба эрсдэлийн нормыг хэт өндөр тогтоож байгаа нь зээлийн хүүг өсгөх үндсэн шалтгаан болж байна.

**Дүгнэлт, зөвлөмж**

Бичил зээлийн хүү ямар нэг механик зохицуулалтаас илүүтэйгээр тухайн зах зээлд оролцогчдын зээлийн эрэлт нийлүүлэлтийн тэнцвэрт харьцаан дээр суурилан тогтдог. Иймд бичил зээлийн зах зээлийн суурь судалгааг оновчтой хийж, нийт оролцогчдын хувьд шаардагдах нөөц, хөрөнгө оруулалтын хэмжээ оновчтой тогтоох шаардлагатай. Үүнд:

- Бичил аж ахуйн тодорхойлолтын хүрээнд албан ба албан бус секторт хамаарах бичил аж ахуйн албан ёсны судалгааг хийх;

- Бичил бизнес эрхлэгчдийн хөрөнгийн эргэц, хэмжээг тогтоон, шаардагдах хөрөнгийн санг бий болгох, хөрөнгийн төвлөрлийг нэмэгдүүлэх;

- Зах зээлийн өрсөлдөөний бодит орчинг бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор хөдөө орон нутагт ажилаж байгаа банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын төсөлд оролцох хувь хэмжээг нэмэгдүүлж, зээлийн нийлүүлэлтээр хүүг бууруулах боломжийг бий болгох.

Төрийн сангийн болон мөнгө зээлийн бодлогын зохицуулалт нь бичил зээлийн хүүг бууруулахад шууд нөлөө үзүүлдэг. Мөнгө зээлийн бодлогын хүрээн дэх зохицуулалт зээлийн хүүд бодит нөлөөллийг үзүүлсэн бөгөөд заавал байлгах нөөцийн хэмжээг бууруулс

- Банк санхүүгийн байгууллагуудын бизнесийн орчинд татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн бодлого үйлчилдэг. Банкууд зээлийн эрсдлийн санг зардлаараа шууд байгуулдаг, санг байгуулсан зардлыг татвараас чөлөөлдөг. Зээлийн эрсдэлийн санг татвараас чөлөөлөх бодлого нь банкны зээлийн чанарыг хамгаалах, банкуудын төлбөрийн чадварын тогтвортой байдлыг хангахад төрөөс үзүүлж буй ихээхэн дэмжлэг болдог. Гэсэн хэдий ч банкууд зээлийн суурь

1 Судалгаанд хамрагдсан хугацаанд банкуудын олгосон бичил зээлийн хүү. 2007 оны 6-р сарын байдлаар  
2 Судалгаанд хамрагдсан хугацаанд банкуудын олгосон бичил зээлийн хүү. 2007 оны 6-р сарын байдлаар

хүүг тооцохдоо эрсдэлийн үнэлгээг хэт өндөр тогтоож байгаа нь банкны зээлийн хүү өндөр байх нөхцөл болж байна. Төрөөс банкинд баримтлах татварын бодлогод өөрчлөлт оруулан зээлийн эрсдэлийн сангийн зардлыг бус нийгэм эдийн засгийн өндөр ач холбогдол бүхий зээлийн хүүгийн орлогыг татвараас чөлөөлөх бодлого баримтлах нь цаашид нийгмийн ач холбогдол бүхий зээлийн хүү буурахад нөлөө үзүүлэх алхам болно гэж үзэж байна. наар түүний зээлийн хүүд үзүүлэх дарамтыг 9% бууруулсан эерэг үзүүлэлтийг үндэслэн зээлийн хүүг шинэчлэн тогтоох шаардлагатай.

#### Ашигласан материал

Ө.Гэрэлт-Од, 2005. Банкны зээлийн эрсдэлийн судалгаа, Улаанбаатар

Ө.Гэрэлт-од, Ж.Уянга, 2007. Санхүү, мөнгөний зээлийн үндэс, Улаанбаатар

Монгол Банк, 2004-2006. Монгол банкны Судалгааны тайлан, 2005-2006

Монгол Банк, 2007. Арилжааны банкны зээлийн багцын судалгаа, 2004-2007.06 сар, Улаанбаатар

ТА төслийн БСХС-ийн бичил зээлийн судалгаа, 2006, Улаанбаатар

ҮСГ, 2004-2006. Монгол Улсын Статистикийн эмхтгэл, 2004-2006, Улаанбаатар